

НОМЫН ШҮҮМЖ

**«МОНГОЛЫН ИМПЕРИАЛИЗМ»  
ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН ТУХАЙ  
ШҮҮМЖ**

1988 оны 5-р сарын сүүлээр АНУ-аар манай академийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж албан ёсны айлчлал хийж явах зуураа АЙРЕКС хэмээх эрдэмтэн солилцох америкийн зөвлөлийн орлогч захирал Матушевскийн зусланд болсон уулзалт дээр Трентон хотын улсын коллежийн профессор Томас Алсэн нэртэй аятайхан зантай найрсаг эрдэмтэнтэй танилцсан билээ. Алсэн надтай ярилцахдаа энд монгол эрдэмтэнтэй уулзахдаа их таатай байна, анх монгол хүнтэй ингэж учирч байна, би одоохон гэртээ очоод ирье, нэг зохиолоо танд дурсгамаар байна гээд яваад удалгүй авчирч бэлэглэсэн ном нь 1987 онд Калифорнид хэвлэгдсэн «Монголын империализм» хэмээх зохиол байлаа.

Алсен их боловсролтой, их юм мэддэг, хятадаар чөлөөтэй ярьдаг, бас монгол хэлийг сонирхдог, даруу төлөв зантай, хамаг сэтгэлээ эрдэм номд зориулсан хүн ажээ.

Өөрчлөн байгуулалт эхлээгүй. Сталин, Чойбалсан, Цэдэнбалыг сохроор тахин шүтэж байсан харанхуй балай, харгис хэрцгий хүнд суртлын захиргаадах арга монгол хүний чөлөөт сэтгэлгээг нухчин боогдуулж байсан үед америк хүмүүстэй уулзаж учрах нь байтугай, энэ тухай үг цухуйлгавал Дотоод яам (сүүлд Аюулаас хамгаалах яам)-ныхны хар дансанд орж, ул мөрөө мөшгүүлж, эцсийн бүлэгт «америкийн тагнуул» хэмээх хилс хэрэгт гүжирдэн гүтгүүлж, амь насаа алдах юм уу, аль эсгүл алс хол цөлөгдөхийн аюулд хүрдэг байсныг дашрамд хэлж, энэ тухай дэлгэрүүлэн үл өгүүлэн өгүүлэх нь:

Энэ номын нэр ялангуяа монгол хүний анхаарлыг тод татах нь аргагүй буйзаа. Тэгээд би америк нөхрийн бэлэглэсэн номын нүүрийн хавтсан дээр улаан өнгөөр дүрсэлсэн морь унасан монгол хааны дүрийг гаргаж, морины нь туурайг дайруулан «Монголын империализм» гэж бичсэнийг үзэж, өнгө утгыг яв цав тохируулсныг гайхав. Нөгөө талаар, америкийн империализмын «өвөг дээдэс» нь Монголын империализм байсан ч юм уу даа гэж хоромхон зуур санагдлаа. Ингэж санагдах нь буруу ч биш байх аа. Яагаад вэ гэвэл, Чингис ба түүний Загамжлагчид нүсэр их байлдан дагуулал явуулж, харийн олон улс орыг булаан эзлэж, дэлхий дээр хамгийн том эзэнт гүрнийг байгуулсан түүхтэй бөгөөд өөрийн болон эзлэгдсэн орнуудын ард түмнийг дарангуйлж байсан. Энэчлэн америкийн империализмын тухай дэлхий дээр ч, АНУ-д ч бишгүйдээ л ярилцсаар ирлээ. Энэ утгаараа монгол, америкийн империализм орон цаг өөр өөр боловч дүйж байгаа байж болох юм.

Харин энэ бол АНУ-ын засаг захиргаанаас сүүлийн үед өөр өөр системийн улс орнуудын хооронд харилцан ойлголцох, итгэлцэх уур амьсгал бий болгох талаар баримталж буй чиг шугамын тухай ярьж буй хэрэг огт бус аа.

Нөгөө талаар, Чингис хаан тэргүүтэй монголын их хаад үндэс ястнаа нэгтгэж их тулгар төрөө мандуулсан их гавьяаг үгүйсгэж буй хэрэг огт бус. Харин ч үүний эсрэг энэ талыг нь өргөмжлөх ёстой гэж байна. Тэгэхдээ гагцхүү миний танил америк түүхчин Алсений «Мон-

голын империализм» гэж бичсэн томъёог ихэд онож хэлсэн үг мөний тухай анхаарлаа төвлөрүүлэх гэсэн юм. «Империализм» гэдэг үгийг америкийн нэвтэрхий тольд үзвэл, үндэснийхээ бодлогыг бусад орон улсад тулган хүлээлгэж, эдийн засаг, улс төрийн ноёрхлоо тогтоохын тулд гадагш байлдан дагуулал хийхийг хэлнэ гэжээ. Гэхдээ капитализмын үеийн империализм утга агуулгаараа огт өөр бөгөөд үүнийг В. И. Ленин капитализмын сүүлчийн шат гэж томъёолсон байдаг.

Орчин үед капитализм, империализм ч ихэд өөрчлөгджээ. Социализм маань чихэд өөрчлөгджээ. Өнөөдрийн олон улсын харилцаа, дэлхий дахины улс төрийн бодлогод өөрчлөн байгуулалт, ил тод байдал, ардчилал зонхилох болж, хүнлэг ёс, нийт хүн төрөлхтний үнэмлэхүй эн тэргүүнд тавигдаж байна.

Одоо уул номын тухайд яривал америкийн түүхчин Алсений «Монголын империализм» хэмээх зохиол 8 бүлгээс бүрэлдэх бөгөөд үүнд 1-р бүлэг нь удиртгал, 2-р нь Мөнх-хаан болтлоо өөд гарсан тухай 3-р нь төвлөрүүлэх бодлого, 4-р нь төвлөрүүлэх бодлогын арга хэрэгсэл, 5-р нь хүн амын тоо бүртгэл, 6-р нь албан татвар, 7-р цэрэг таталт, 8-р нь төгсгөл ба дүгнэлт болно. Зохиолын бүгд хуудас -278.

Томас Алсен зохиол бичсэн арга барилынхаа тухай өгүүлэхдээ Монголын эзэнт гүрэн түүхийн явцад Юан улс, Алтан Ордоны улс, Их хаадын Иран улс зэрэг олон хэсэг хаант улсууд болон хуваагдсаныг тус тусад нь салангид судалсаар ирснийг шүүмжлэн, эл судалгаага Мөнх хааны үеэр зааглан, Монголын эзэнт гүрнийг бүхэлд нь авч үзэх зорилготой гэжээ. (х. 10). Иймд, зохиогчийн бодохоор, «Миний хандлага бол үйл явдлыг бүхэл бүтэн эзэнт гүрний ирээдүйн төлөв, монгол хаадын байр сууринаас авч үзэхэд оршино» гэжээ. (х. 10).

Зохиогч номоо эхлэхдээ Мөнх хааны улс төр, эдийн засгийн бодлого бүх эзлэгдсэн улс орны ард түмний амьдралд айхавтар нөлөө үзүүлсэн бөгөөд чингэснээрээ олон түүхчин, он дарааллын бичиг туурвигчдын анхаарлыг зүй ёсоор татсан юм гэж тэмдэглэжээ. (х-11).

Зохиогч энэ номоо туурвихдаа Хятад, Иран, Орос, бусад эзлэгдсэн орны он дарааллын бичгүүдийг дурьдаад, монголын сурвалж бичгийн тухай өгүүлэхдээ «Нууц товчоо»-г онцлон заасан байна. «Нууц товчоо»-нд Өгөөдэй хааны үеэс хойшихыг дурьддаггүй ч гэлээ гэсэн, Мөнх хааны хаанчлалын улс төрийн бааз суурийг мэдэхэд онц чухал юм гэсэн байх юм.

Америкийн түүхчин Томас Алсен хэрхэн их хаан Мөнх Монголын эзэнт гүрнийхээ улс төр, эдийн засаг, цэргийн хүчин чадал, нөлсийг дайчлан төвлөрүүлж, Чингис богдынхоо захиснаар эзэнт гүрнийхээ хил хязгаарыг тэлэхээр Номхон дөлгөөн далайгаас Адриатын тэнгис хүртэлх асар уудам газарт байлдан дагуулал хийж байсан тухай түүхийн олон тооны сурвалж бичиг, судалгаа шинжилгээний зохиолуудад түшиглэн өөрийн гэх санаа дүгнэлттэй бичсэн байна.

Зохиогч Монголын их хаан Мөнхөөс Хятад, Орос, лалын шашинт орнуудад 1251-1259 онд явуулж байсан улс төрийн бодлого, байлдан дагууллын тухай арвин их баримт материалд түшиглэж бичжээ.

Зохиогч цааш нь тодруулан бичихдээ Монголын эзэнт гүрний их цэрэг өгүүлж буй үед Польш, Галици, Сири, Иран, Ирак, Кашмир, Өмнөд Хятад, Төвд, Энэтхэг-Хятад, Солонгосыг хамарсан байлдан дагуулал хийснийг дурьдаад Их хаан Мөнх энэхүү байлдан дагууллыг явуулахдаа Чингис хаанаас монголчууд дэлхийн бүх улс орныг эзлэх ёстой гэсэн зарлигийг биелүүлэхийг хичээсэн юм гэжээ. Ингэж харийн орныг эзлэхийн өмнөх урьдчилсан бэлтгэлээ сайн хийж, арга тактик боловсруулж, газар нутгийн байдлыг нарийвчлан тогтоож, нөгөө талын хүчин чадлыг зөв дэнсэлж үзээд, дараа нь цэргийн жанж-

нууддаа тодорхой зарлиг буулгаж, сайтар зөвлөлдөн хэлэлцэж дайран ордог байж гэжээ. (х.1)

Мөнхийг Монголын эзэнт гүрний хаан ширээнд өргөмжлөхөд Чингисийн удмынхны дотор ихээхэн зөрөлдөөн гарч байсныг америкийн түүхч хөндөн бичсэн байна. Цагаадай, Өгөөдэйн ураг төрлийнхний зарим нь Мөнхийг хаан залах хурилтайд ирэхээр болсонд, ихэнх нь татгалзсаар байжээ. Иймээс Мөнх хаан ширээнд залах ёслол хойшлогдон сунжирах болов. Эцсийн эцэст Баруун зүгт байлдаж явсан Бат бодохдоо Чингис эзэн хааны ураг төрлийнхнөөс үл захирагдагсдын байх байхгүй хамаагүй хурилтайг зарлан хуралдуулах нь зүйтэй гэж үзжээ. Тэгээд Бат биеэрээ ирж чадсангүй, өөрийн дүү Бэрх, Сартаг нарыг явуулжээ.

Ийнхүү хурилтай Хэрлэнгийн эргийн дагуу орших хөдөө арал хэмээх газраа 1251 оны 6—7-р сард хуралджээ.

Уул хурилтайд мөн Хубилай, Хулагуу, Ариг Бөх, Мөнх хааны өөрийн ах дүү нар тэргүүтэн олон ноёд хэргэмтэн оролцсон билээ.

Монголын эзэнт гүрний хаан ширээнд ийнхүү 42 настайдаа Мөнх суужээ. Мөнх 1209 оны 1-р сарын 10-нд Чингис хааны отгон хөвгүүн Тулуйн бага хатан Бэки-гийн ахмад хөвгүүн болон төрсөн билээ.

Мөнх хаан эдийн засаг, засаг захиргааны шинэчлэл хийхдээ Их гүрний засаг төр, санхүүг системчлэн зохицуулахыг чухалчлан үзэж, нэгд, байлдан дагуулах төлөвлөгөө биелүүлэхэд шаардагдах бүхнийг дээд хэмжээгээр дайчлах, хоёрт, төв болон бүс, орон нутгийн засаг захиргааг хөнгөн шуурхай ажиллуулж, хаан эзэнд үнэнч байх явдлыг хангах зорилгоо тавьжээ. (х.78—79)

Мөнхийн байлдан дагуулах бодлого бүх Монголын ноёдыг нэгдэлтэй байлгах хүчин зүйл болж байжээ. Тэдний тус тусын улс төр, нийгмийн бодол хэдүй өвөрмөц байлаа ч, тэд Мөнхийг хаан ширээнээ суусан явдлыг хувь хувьдаа өөр өврөөр үзэж байлаа ч гэсэн, бүгдээрээ нэг гол үзэл баримталж байсан нь: Их Монгол улсын сүр сүлд нь байлдан дагуулал байх ёстой гэж үзэж билээ. (х.79)

Мөнх хаан өргөн хэмжээгээр байлдан дагуулал явуулахдаа юуны өмнө эдийн засаг, цэргийн хүч чадал, нөөц бэлтгэлээ сорьж үздэг байжээ.

Би номын нь бүлэг бүхний талаар саналаа хэлэх бус, зарим нэг онцлог гэсэн асуудлаар зохиогчийн байр суурийг авч үзнэ.

Зохиогч хүн амын тоо бүртгэлийн тухай бүлэгт өгүүлэхдээ энэ ажил бол орчин үеийн бүх улс үндэстэнд нийгмийн хяналт шалгалтыг явуулж, бүх бололцоогоо дайчлах чухал хэрэгсэл мөн бөгөөд урьдын эзэнт гүрнүүдэд ч бас ийм байсан гэжээ. (х. 116) Ийм тоо бүртгэлийн ажил явуулах явдал Монголд ч байсан нь тодорхой бөгөөд ард иргэдээ малчин, тариачин, хотынхон гэж ялгаагүй зохицуулан удирдаж мөлжихөд эзэнт гүрний аппаратыг чиглүүлэх гол арга байлаа.

Эзэнт гүрнээ 1206 онд тунхагламагц Чингис хаан татараас олдсон хаяцын Шиг-ихутагийг дүүгээ (буюу хөвгүүнээ) болгон авч, шинэ тогтносон төрийнхөө хууль цаазын хэргийг эрхлүүлэн, байлдан дагуулсан ард түмнийг эзэн хааны гэр бүлийнхэнд адил тоотой хуваариулан зохицуулахаар шийдвэрлэжээ. Энэ бүх хэргийг маш нарийн хөтөлсөн «Хөх дэвтэрт тэмдэглэж, хойчийн засгийн хэрэгцээнд үлдээж билээ. Энэхүү зарлигийн зорилго хоёр байсан нь, нэгд, алив айлтгал шийдвэрийг үлдээж байх, хоёрт, янз бүрийн ноёд болон цэргийн эрх тэндээ албат иргэд, хувь газар олгосон тухай мэдээг бэлхэн байлгаж байхыг чухалчилсан ажээ. (х. 116)

Зохиогч нэг сонирхолтой асуудлыг хөндөж өгүүлэхдээ, нэг талаас Өгөөдэй хааны дэргэдэх хятад сайд зөвлөх Елюй Цуцай, нөгөө талаас Монгол эзний хооронд хүн амын тоо бүртгэлийн талаар багагүй зөрчил байсныг тэмдэглэж байна. Хэрэв Хятад сайд хүн амын тоо бүртгэлийг шинээр явуулахдаа Хойд Хятадад уламжлалт хятад засаг захиргааг сэргээн босгохын хамт хувь газар эзэмшилтэй монгол язгууртны эрх мэдлийг хязгаарлах, чингэснээрээ хятад маягийн засаг явуулахыг мөрөөдөж байсан ахул монгол эрх баригчид энэ асуудлыг огт өөрөөр үзэж, Хятадаас орох орлогыг өсгөж, хувь газрын хэмжээг өргөтгөн тэлж ашиг ихээр олох эх булаг болгохын төлөө байжээ. (х. 117—118).

1236 онд эзэн хаан зарлиг буулгаж, хааны ураг төрлийн ноёдод шинээр хувь газар хуваарилан олгосон нь Хойд Хятадын хүн амын бараг тал хувь монгол язгууртны албат болсон байжээ. (х. 118). Иймээс Елюй Цуцайн улс төр, нийгмийн шинэчлэл явуулах оролдлогод ийнхүү хатуу цохилт болжээ.

Эзэнт гүрний хүн амын тооллогыг бүрэн хэмжээгээр Мөнх хаан 1252 онд явуулж амжилттай дуусгажээ. Жувейний он дарааллын бичигт өгүүлэхдээ Мөнх хаан хүн амын тооллого хийлгэхээр заргууч, бичээч (эдгээр нь бие төлөөлөгч, түшмэд гэсэн утгатай) нарыг Хятад, Орос, Иран, Кавказ руу явуулж тэдэнд хаа яваа газарт нь орон нутгийн захиргаа болон цэргийн эрхтэний талаас дэмжлэг үзүүлж байх зарлиг буулгажээ. (х. 118—119)

Хүн амын тоо бүртгэл явуулснаар Мөнх хаан ердөө л эдийн засаг, цэргийн байдлыг дэнсэлж суудаг байсан энэ явдал дайн дажин болоход бүх эзэн хаадыг орой эрт боловч түгшүүлдэг асуудал ажээ. (х. 121). Насанд хүрэгсдийн бүртгэлээс чөлөөлөгддөг нэг хэсэг давхарга байсан нь лам нар ажээ. Тэд тэр ч байтугай албан татвараас ч чөлөөлөгддөг байжээ.

Юань-Ши-г иш татан зохиогч хэлэхдээ 1252 онд Мөнх хаан бүх Хятад даяар цэргийн тоо бүртгэлийг шалгуулахаар Мэргэд аймгийн Хөхөөг илгээж байсан юм гэжээ. (х. 123). Үүний зэрэгцээ бас энгийн иргэдийн бүртгэлийг хянуулсан ажээ.

Монголчууд булаан эзэлсэн улс орнуудыг байлдаанд ялагдснаа хүлээсэн төдий үзэхгүй, дэлхий дахиныг цаашид байлдан дагуулахад нь дайвар хүч болох ёстой гэж үзэж, тэр ёсоороо ч орон орноос цэргийг нь дайчилж, байлдааны шугамын аль эгзэгтэй эгнээнд явуулан дайжуулна.

Цаашид зохиогч хэрхэн хүн амын тооллого Мөнх хааны үед Ин ан, Солонгос, Орос зэрэг эзлэгдсэн орнуудад явагдаж байсныг дурьджээ.

Жишээ нь, Монголын харьяанд орсон Оросын Новгородад 1259 онд хүн амын тооллогоор очсон Бэрх тэргүүтэй бичээчүүд нутгийн ардаас эмээж, Александр Невскийг өөрийг нь дагуулан, тооллого хийж явсан билээ. (х-140)

Монголчууд Хятад, Орос, Иран мэт эзлэгдсэн орнуудад хүн амын тоо бүртгэл явуулахдаа өвлийн улирлыг сонгож байсан нь газар тариалангийн ажил дуусаад хүн иргэд гэр орондоо байхыг харгалзсан хэрэг байх аа гэж зохиогч дүгнэсэн нь ортой болов уу гэж бодогдоно. (х. 143)

Алсен бичихдээ Монголын хаад, жишээ нь, Хятадаас татсан цэргийг «Хар цэрэг» хэмээн нэрлэж, өөрсдийн цэргийн хүчээ зузаатган, байлдах дайтахдаа ашигладаг байжээ. 1241 оны үеэр Монголын эзэнт гүрний хятад цэрэг 97575 хүрч, «шинэ арми» гэж нэрлэгдэж билээ. (х. 195). Мөнх хаан ширээнд сууснаас ч хойш «шинэ арми» хэвээр байжээ. Цэрэгт татагдсан хятадуудыг мөн л монгол маягаар түмэт,

мянгат хэмээн зохион байгуулалтын нэгжид хуваан захирна. 1250-иад оны эцсээр Сүн улсыг дайлаар мордоход, Рашид-ад-Дины тооцоолсноор, 90 түмэн цэрэг байснаас Мөнх хаан өөрөө 60 түмэн цэргээ авч баруун жигүүр хийж, Хубилайн захирсан зүүн жигүүрт 30 түмэн цэрэг багтаж билээ. х(197)

Үүнээс үзэхэд Монголын хаад Хятад, Орос болон өөр бусад орныг байлдан дагуулахдаа тухайн орноос дайчилсан цэргийг мөн ашиглаж, байлдах хүч чадлаа зузаатгаж байсан нь тодорхой ажээ.

Үүнтэй холбогдуулан нэг зүйлийг сонирхуулан хэлэхэд хэрэв монголын их хаадын үед хятадын «хар цэрэг» монгол жанжинд захирагдаж, монголчуудын байлдан дагуулалд оролцож явсан ахул, сүүлд манжийн ноёрхол Хятад, Монголд нуран унаж, Монголд Богд хаант улс тогтносон 1911—1919 онд монголчуудыг хятадын «хар цэргээр» айлгадаг болсон нь үнэнхүү улирах цагийн эрхээр түүхийн үйл явдал огт эсрэгээр эргэн өөрчлөгдөх ёсон буйг харуулж байна биш үү.

Түүнчлэн, ХШ зууны үед дэлхий дахиныг донсолгож байсан монголын эзэнт гүрэн мөн л улирах цагийн эрхээр хумигдан хуваагдсаар гурван хэсэг болон, гагцхүү Төв Монгол одоо Бүгд Найрамдах Монгол Ард Улс байгаа нь бас нэг жишээ мөн.

Бусад улс орнуудыг ч авч үзсэн тэр, дэгжиж буурч, эсвэл үл буурч дэгжиж байсан түүх олонтоо тохиолдоно.

Одоо Алсений зохиолд эргэн олж үргэлжлүүлбэл, Мөнх хаан хятадын Сүн улсыг эзлэх үед Хубилайн шатар хишигтэний дотор Болд хэмээх цэргийн их түшмэл байж, ирээдүйн хааны итгэл найдварыг авсан ажээ. Хубилай хаан болсоны дараа Болд Шү-ми-юан хэмээх нууц зөвлөлд ажиллаж байгаад, Иранд томилогдсон ажээ. (х. 197)

Мөнх хаан Дорнод Азид явуулсан дайнд монгол цэргийн дотор хятадаас гадна тангуд, зүрчид, солонгос цэргийг ашиглаж билээ. (х-200). Жишээ нь: Аннамыг эзлэхэд Нан-Чао-гаас 2 түмэн, Сечуан мужийг эзлэхэд Уйгар улсаас 1 түмэн цэрэг татаж, Ар Кавказын Аланчууд мөн дайнд бас нэг түмэн цэрэг нийлүүлж байжээ (х200)

Энэ тухай Монгол-татарууд Ази, Европт» (Москва, 1977) хэмээх монгол, зөвлөлтийн эрдэмтдийн хамтын бүтээлд ч дурдсан байдгийг иш татаж болно. Мөнх хааны дүү Хулагуу 1256 онд их цэрэгтэйгээ Иранд очиж хаан суужээ. Тэндээс Хулагуу Багдадыг эзлэхдээ армян гүржийн вангуудыг цэрэгтэй нь дайчилж, хүчээ зузаатгаж байсан ажээ. Хулагуу цаашаа Иерусалим руу армяны хаан Гетумтэй хамтран байлдан дагуулал хийхээр завдан байтал их хаан Мөнх нас барсан тул больж, монгол нутагтаа буцжээ. Сирид үлдсэн монгол цэргийн ерөнхий жанжнаар Кит-Бугыг тавьж байсныг энд нэмж өгүүлмээр байна.

Мөнх хаан гадагшаа харь орныг байлдан дагуулахдаа нарийн чанд бэлтгэл хийхээс гадна, дотоодоо төвхнүүлэхийг нэгэн адил эрхэмлэдэг байсан тухай өмнө өгүүлсэн билээ. Үүнд, нэг талаас Монголын эзэнт гүрнээ эдийн засгаар доройтуулбал хүчин мөхөсдөж их цэрэг хөдөлгөж чадахгүйд хүрэх тул феодал ноёд, цэргийн эрхтэн ноогдсон хувь эзэмшил газартаа албат хамжлагат нараа хэтэрхий мөлжиж мөхөсдүүлэхээс болгоомжилж байжээ.

Энэ тухай уул номд өгүүлэхдээ хэдийгээр Мөнх хаан хувь газар эзэмших системийг хэвээр үлдээж, зарим талаар өргөжүүлсэн боловч, төд удалгүй эзэмшил хувь газруудад, ялангуяа дарлал зовлон хэтэрсэнд нь байдлыг засах талаар арга хэмжээ авч, түүнийг төр засгийн хяналтад авч байжээ гэжээ. (х86) Үүнийгээ зохиогч зөв зүйтэй тайлбарлахдаа эцсийн бүлэгт Мөнх хаан энэ мэт «шинэчлэл» хийсэн нь тариачид, гар үйлдвэрчдийн аж амьдралыг дээшлүүлэхийн төлөө хэрэг

бус харин эзэнт гүрнийхээ эд агуурсыг чөлөөтэйгээр арвижуулж байхыг чухалчилжээ гэсэн байна. (х 91)

Америк зохиогчийн энэ үг тэр үеийн түүхийн ээдрээтэй үйл явдлын нэгэн үзэгдлийг бодитой дүгнэснийг харуулж байна.

Өөр нэг хуудаснаа зохиогч бичихдээ Эзэнт гүрний иргэдийг хэтэрхий хууль бусаар дарлан мөлжигч ноёд феодалуудыг Мөнх хаан зэмлэн буруушааж шийтгэж байсан нь тэднийг ёс суртахууны үүднээс ёсон бус хэрэг үйлдэв гэж гэсгээсэн хэрэг бус харин бараа таваар, эрх ямбаар хаантайгаа өрсөлдөж байгаатай нь холбож үзэх ёстой гэжээ. (х.92). Ард иргэд амьдралаа залгуулж байхад наад зах нь ямар нэг хэмжээ авч амгалан тайван байдал, идээ будаатай байлгах шаардлагатай байх нь мэдээж хэрэг хэрэв тэгэхгүй, феодал ноёд эзэмшил газар дээрх хамжлагат ардаа хэт мөлжигч тамир тэнхээг барвал эзэнт гүрний хүч, сүр нөлөө буурна гэж Мөнх хаан бодож байсан ажээ. Иймээс зохиогч ямар дүгнэлтэд хүрсэн вэ гэвэл, Мөнх хааны зорилго эзэнт гүрний ардаас аль болох их хэмжээгээр алба гувчуур татахын зэрэгцээ тэдэнд амь зуух төдий хэрэгцээний эд агуурсыг бүрмөсөн цөлмөдөггүй байлаа гэжээ. (х-92) Түүнчлэн Мөнх хааны энэ талаар олсон амжилтын чухам учир бол улс орноо нийгэм, эдийн засгийн хямралд оруулахгүйгээр ноёд феодалын авч идэх, хээнцэрлэх хэмжээгүй шуналыг нь дарж чадаж байсанд оршино. ( мөн тэнд)

Үүнтэй холбогдуулан америкийн түүхчин Алсен бас нэг сонирхолтой санаа гаргасан нь Мөнх хаан энэ мэт шинэчлэл явуулахдаа улс төр, эдийн засгийн тооцоон дээр үндэслэсэн болохоос биш, Күнзийн суртлын нөлөөгөөр чингэсэнгүй гэжээ. (х.93)

Дээр дурьдсанаас үзэхэд америкийн түүхчин Томас Алсен Монголын их хаан Мөнхийн үеийн түүхийг арвин их материалд түшиглэн нэлээд бодитойгоор харуулж чадсан гэж болно.

Энэхүү шүүмжийн эхэнд хэлсэн зүйлээ эргэж давтал Томас Алсен Мөнх хааны үеийн Монголын эзэнт гүрний хийсэн байлдан дагуулал үнэхээр бүх дэлхий даяар Монголын ноёрхлыг тогтоох ганцхан стратегийн гол зорилтын дор явагдсан болохоор номоо “Монголын империализм» гэж нэрлэсэн нь ямар нэг хэмжээгээр оносон хэрэг мөн. Тэгэхдээ энд хэрэглэсэн «Империализм» гэдэг томъёо улс орныхоо газар нутгийг гадагш тэлэх утга агуулсныг тэмдэглэх хэрэгтэй.

Ер нь империализм түүхийн явцад, Лениний хэлснээр, капитализмын сүүлийн шат болсон билээ.

Бид марксизм-ленинизмын үндсэн зарчим, гол чиглэлүүдийг орчин үеийн нийгмийн амьдралын хүрээнд гүнзгийрүүлж хөгжүүлэхээс биш аль нэг үг дүгнэлттэй зууралдаж салахгүй, түүнийг нь абсолют үнэн гэж үзэж, өөрийн оюун ухаанаар сэтгэхгүй байж болохгүй бизээ.

Өнөөдөр 1990 оны цагаан морин жилтэй бид золгож байгаа үед капиталист империализм ч ихэд өөрчлөгджээ. Социализм ч ихэд өөрчлөгджээ.

Америкийн түүхчид энэ мэтээр Монголын эзэнт гүрний их хаадын түүхийг нарийвчлан судалж, ном зохиол туурвиж байгаа нь сайшаалтай хэрэг мөн.

Саяхан хүртэл, өөрчлөн байгуулалт явагдахаас өмнөхөн манай Монголд америкийн, ер нь хөрөнгөтөн орны түүхчдийн туурвисан бүтээлүүдийг муу талаас нь өөлж төнхдөг явдал бараг заншил болсон ажээ. Сайн тал, бодитой бичсэн зүйл байвч ер үзэхгүй, харахгүй мэт байдаг.

Ингэж манай нийгмийн ухааныхан хуучин суртал, ангийн үзэлдээ баригдан хүлэгдэж, улс төрийн үгээр хэлбэл, харалган болцгоож,

үзэгдлийг бодитойгоор авч үзэж, судалж чадахаа больж, дэлхийн түвшингээс хол хоцроход хүрлээ. Үүнээс болж, капиталист орнуудад нийгмийн ухаанаар, тэр ч байтугай, байгалийн ухаанаар социалист орнуудыхаас илүү бүтээл гарч болно, гарсаар ч байгаа гэдэг энэ үнэ нийг үгүйсгэсээр өөрсдөө хоцорлоо.

Ийм үнэнийг одоо хүлээн зөвшөөрөх цаг боллоо.

Бид өнгөрсөн түүхээ сайн ойлгож байж гэмээж нь өнөөдөр хөлөө олж чадна, өнөөдөрөө сайн ойлгож байж гэмээж нь маргаашаа сайн төсөөлж чадна.

**Ш. САНДАГ**

(үргэлжлэлийг дараагийн дугаарт)

## **БНХАУ-ЫН ХҮН МЫН АСУУДАЛ**

«Проблемы народонаселения» М., «Прогресс» 1989. 312 с.

Эл эмхэтгэлд Хятадын хүн амын өсөлт, төвлөрөл, гэрлэлт, өрх бүслийн байдал болоод нийгэм-эдийн засгийн хөгжлийн хоорондын нөлөө, шүтэлцээ, төрөлтийн хязгаарлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам зэрэг сэдвээр хятад, америкийн нэрт хүн ам зүйч эрдэмтдийн бичсэн шинжилгээний өгүүллүүдийг Зөвлөлтийн эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн Баженова Е. С., Судоплатов А. П нар хэсэг орчуулагч лугаа хүч хавсран эх хэл бүрээс нь орос хэлнээ орчуулан нийтэлжээ.

Тус эмхэтгэлд хятадын өөрий нь болон өрнөдийн хүн ам зүйн томоохон эрдэмтэн судлаач тухайлбал Хятадын хүн ам зүйн төвийн эрдэмтэн Лю Жэн, Тянь Сюеюань, Гу Зяньтань нар болон америкийн хүн ам судлалын нэртэй мэргэжилтэн Дж. Бонгаартс, С. Гринхалф зэргийн бүтээлийг оруулжээ. Энэ ном өнөөгийн хятадын хүн амын асуудлын гол ээдрээ түүнийг тайлах арга замын тухай уншигчдад таниулан ойлгуулах зорилго агуулжээ.

Хятад улс хүн амын тоогоороо дэлхийд нэгдүгээрт орох бөгөөд 1987 оны сүүлч гэхэд 1,080 тэрбум хүнтэй болжээ. 1949 онд БНХАУ байгуулагдсаны дараа 540 сая хүнтэй байж, түүнээс хойшхи 38 жилийн дотор Хятадын хүн даруй 2 дахин нэмэгдсэнээр эдүгээ дэлхийн хүн амын 22 хувийг эзэлж байна. Хүн амын суурьшил нягтрал маш тэнцвэргүй 1/10 нутаг дэвсгэрт хүн амын 80 % амьдарч байхад, Дорнод мужуудад хүн амын нягтрал 1 хав, дөр.км-т 590 хүн ногдож байна. Дэлхий даяар, хүн амын тоог тооллогын дүнгээр гаргадаг дэлгэрсэн арга бий. БНХАУ байгуулагдсан цагаас хойш 3 удаа тооллого болов. Үүнд: 1953 онд 601,9 сая, 1964 онд 723,1 сая, 1982 онд 1008,2 сая хүнтэй байлаа.

Эмхэтгэлийг хятадын томоохон хүн ам зүйч Лю Жэний «БНХАУ ын хүн ам» өгүүллээр эхэлж байна. (26—63 дахь тал). Түүний бүтээлд хүн ам зүйн байдлын үндсэн шинжүүдийг нарийн тодорхой гаргажээ. Үүнд сүүлийн арван жил дэх хүн амын өсөлтийн ерөнхий байдлыг шинжлэн тодорхойлсны зэрэгцээ улс орны нийгэм эдийн засгийн хөг-